



“АЛТАНБУЛАГ” ЧӨЛӨӨТ БҮС

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

АГУУЛГА

БИДНИЙ ТУХАЙ

ҮЙЛ АЖИЛЛАГАА


ДЭД БҮТЭЦ

ТАТВАР, ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ

ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

НӨХЦӨЛ БАЙДАЛ

НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ



“АЛТАНБУЛАГ” ЧӨЛӨӨТ БҮСЭД ТАВТАЙ МОРИЛНО УУ

ОРШИЛ

“Чөлөөт бүсийн тухай” хуулинд заасанчлан тус чөлөөт бүсэд гаалийн, визийн, Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн зорчих, хуулийн этгээдийн бүртгэлийн, валют зохицуулалтын, хяналтын, хөдөлмөр эрхлэлтийн, татварын болон бусад тусгай дэглэм үйлчилнэ.

Та бүхэнд толилуулж буй энэхүү гарын авлага нь чөлөөт бүсэд мөрдөх татвар, гааль, шалган нэвтрүүлэх, хуулийн этгээдийн бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэмийн эрх зүйн зохицуулалтуудыг энгийн хялбар үгээр тайлбарлан таниулахад оршино.

БИДНИЙ ТУХАЙ


Монгол Улсын анхдагч “Алтанбулаг” чөлөөт бүс нь Ази-Европыг холбосон стратегийн ач холбогдол бүхий замын зангилаа хэсэг, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт оршдог. Монгол Улсын УИХ-ын Засгийн газрын тогтоолоор 2014 онд үйл ажилагааны байнгын дэглэмд шилжсэн. Өнөөгийн байдлаар тус чөлөөт бүс нь худалдаа, үйлчилгээний чиглэлээр ажиллаж байна. (100% төрийн хөрөнгө оруулалттай).

ТҮҮХЭН ЗАМНАЛ

“Цайны зам” дагуу түүхийн Маймаачин хот нь одоогийн Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум, “Алтанбулаг” чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт байсан түүхэн замналтай. Маймаачин—Хиагт боомтод арилжаалагддаг гол бараа нь цай байсан учраас уг боомтыг дайрсан замыг “Цайны зам” гэх болжээ. “Цайны зам” нь Ухань-Бээжин, Бээжин—Хаалган, Хаалган хот—Их Хүрээ, Их Хүрээ-Маймаачин-Троицкосавск (Хиагт), Троицкосавск—Верхнеудинск (Улаан-Үд), Верхнеудинск—Тобольск—Нижный Новгород—Москва гэдэг маршруттай бөгөөд Бээжингээс Москва хүртэл нийт 9000 орчим км үргэлжилдэг байжээ.

ҮЙЛ АЖИЛЛАГАА, ААН-ИЙН БҮРТГЭЛ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Алтанбулаг чөлөөт бүсэд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар тогтоосон шаардлагад нийцсэн үйл ажиллагааг явуулж болно:




ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ:

Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх, тамхи худалдаалах

Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх, тамхи худалдах зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу олгоно.

Экспортлох зорилгоор уламжлалт технологиор үйлдвэрлэх согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг Засгийн газрын баталсан журмын дагуу олгоно.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ. ЧӨЛӨӨТ БҮСИЙН ГЭРЧИЛГЭЭ:



(АЖЛЫН 5 ХОНОГТ ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ БА УГ ГЭРЧИЛГЭЭ НЬ ЗӨВХӨН ТУХАЙН ЧӨЛӨӨТ БҮСЭД ХҮЧИН ТӨГӨЛДӨР ҮЙЛЧИЛНЭ).



(АЖЛЫН 5 ХОНОГТ ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ БА УГ ГЭРЧИЛГЭЭ НЬ ЗӨВХӨН ТУХАЙН ЧӨЛӨӨТ БҮСЭД ХҮЧИН ТӨГӨЛДӨР ҮЙЛЧИЛНЭ).

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ДЭЭР:

- Захирагчийн ажлын албанд бүртгүүлсэн хуулийн этгээд нь бусад хуулийн этгээдтэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж болох чөлөөт бүсэд гэрээгээр хамтран ажиллах хуулийн этгээд
- Чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ авна.



ДЭД БҮТЭЦ, ЛОГИСТИК БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Алтанбулаг чөлөөт бүсийн **500** га газрын 93.7 га газарт дэд бүтцийн барилга байгууламж хийгдсэн

Ирээдүйд

- Төмөр зам, логистикт түшиглэсэн чөлөөт бүс болно

ДЭД БҮТЦИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

- Цахилгаан түр шугам 3,8 км бкВ цахилгаан хангамжийн түр шугам, 2610 кВа хүчин чадалтай 4 дэд өртөө
- Ариутгах татуурга: Бохир усны 25 км шугам, насос станц нь хоногт 5700 м³ бохир тээвэрлэх хүчин чадалтай
- Үерийн ус зайлуулах байгууламж 9,4 км секундэнд 15м³ урсгах хүчин чадалтай
- Цэвэр ус хангамж 11 км шугам. Гүний усны 7 худаг, өргөтгөлийн насос станц, усан сангаас бүрдэнэ. Хоногт - 6300 м³ усаар хангах хүчин чадалтай



ТАТВАРЫН ДАВУУ ТАЛ: ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ

Татварын харьцуулалт	Монгол Улс	Алтанбулаг чөлөөт бүс
Импортын татвар	5%	0%
НӨАТ	10%	0%
ХХОАТ	2%-10%	0%
ААНОАТ	1%-10%	0%
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0,6%-2%	0%

НӨАТ, ИМПОРТ, ЭКСПОРТ- “АЛТАНБУЛАГ” ЧӨЛӨӨТ БҮС, МОНГОЛ УЛСЫН ХООРОНД

Гадаад улсаас “Алтанбулаг” чөлөөт бүс рүү импорт хийх	0% (импортын татвар)
	НӨАТ-0%
	ОАТ-0%
“Алтанбулаг” чөлөөт бүсээс гадаад орон руу экспорт хийх	Экспортын татвар-0%
	НӨАТ-0%
“Алтанбулаг” чөлөөт бүсээс Монгол нутаг дэвсгэр руу оруулахад	Зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй бараа:
	Гаалийн татвар-0%
	НӨАТ-0%
Монгол Улсаас “Алтанбулаг” чөлөөт бүс рүү импорт хийх	0% (импортын татвар)
	НӨАТ-0%
	Монголын бараа бүтээгдэхүүн: НӨАТ-0%

МОНГОЛ УЛСАД ИМПОРТЛОГЧ КОМПАНИ 0%-40% ИМПОРТЫН ТАТВАР ТӨЛДӨГ, НӨАТ 10% ТӨЛДӨГ

ХӨНГӨЛӨЛТ ЧӨЛӨӨЛӨЛТ

- Чөлөөт бүсэд зориулсан эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах татуурга, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтцэд 500.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг;
- Чөлөөт бүсэд агуулах, ачиж буулгах байгууламж, зочид буудал, аялал жуулчлалын цогцолбор, импортыг орлох болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад 300.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг;
- Чөлөөт бүсэд баригдаж бүртгэгдсэн барилга байгууламжийг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас бүрэн чөлөөлөх

ТУСГАЙ ДЭГЛЭМИЙН ЗОХИЦУУЛАЛТ

ГААЛИЙН ТУСГАЙ ДЭГЛЭМ

- Хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах бараанд ачааны манифест, тээврийн баримт бичиг, шаардлагатай тохиолдолд холбогдох зөвшөөрөл;
- 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийнэ.
- Хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргах бараанд тарифын бус хязгаарлалт тогтоохгүй.
- Барааг хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргахад гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийнэ.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТУСГАЙ ДЭГЛЭМ

- Чөлөөт бүс дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсэн бол ажлын байрын төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөнө.
- Чөлөөт бүсэд ажиллаж байгаа хуулийн этгээд өөрийн ажилтныг чадваржуулах, мэргэшүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн тохиолдолд зардлыг тухайн жилийн татвар ногдох орлогоос хасаж тооцно.

ВИЗИЙН ТУСГАЙ ДЭГЛЭМ

- Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй болон “орох-гарах” визтэй гадаадын иргэн оршин суух болон визийн байх хугацаанд аль ч чөлөөт бүсэд визгүй зорчино.
- Хил залгаа улсын иргэн 30 хоногийн хугацаагаар визгүй, гуравдагч улсын иргэн харилцан зорчих нөхцөлтэй гэрээтэй гадаадын иргэн, харьяалалгүй хүний визийн байх хугацаа болон визгүй зорчих хугацааг нэг удаад 30 хүртэл хоногоор сунгаж болно.

ТАТВАРЫН ТУСГАЙ ДЭГЛЭМ

- Импортын гаалийн, онцгой болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлж гаалийн нутаг дэвсгэрт оруулсан барааг чөлөөт бүсэд оруулахад татвар ногдуулахгүй бөгөөд гаалийн нутаг дэвсгэрт тухайн татварыг төлсөн баримтыг үндэслэн бусад татвараас хасалт хийж буцаан олгоно.
- Чөлөөт бүсэд бүртгэлтэй иргэн, хуулийн этгээдийн чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд НӨАТ ногдуулахгүй.

ЧӨЛӨӨТ БҮС ДЭХ ТӨЛБӨР ТООЦООГ ГҮЙЦЭТГЭХ ЗОХИЦУУЛАЛТ

- Чөлөөт бүсэд төлбөр тооцоог үндэсний болон гадаад валютаар гүйцэтгэнэ.
- Чөлөөт бүсэд банк, банк бус санхүүгийн байгууллага, түүний салбар нэгж байгуулахтай холбогдсон харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

ХУУЛИААР ЗОХИЦУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Чөлөөт бүс дэх төрийн үйлчилгээ нь худалдаа, татварын харилцаа, бизнес, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх цахим нэг цонхны үйлчилгээнд суурилна.
- Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэн нь чөлөөт бүсийн захирагчтай байгуулсан гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө дампуурснаас бусад шалтгаанаар татан буугдсан буюу чөлөөт бүс дэх үйл ажиллагаагаа зогсоосон тохиолдолд хөнгөлж, чөлөөлсөн татварын хувь хэмжээний нийлбэрээр тухайн аж ахуйн нэгжийн татварын өрөнд шилжүүлэн тооцно

БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ТОХИОЛДОЛД:

- Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг дараах үндэслэлээр чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлээс хасна:
- Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ олгосон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд гэрээ, дүрэмд заасан үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээг эхлүүлээгүй;
- Үйл ажиллагаагаа эхлүүлсэн боловч дараалсан 12 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаа нь өөрөөс хамаарах шалтгаанаар тасалдсан, зогссон;
- Татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан.

НӨХЦӨЛ БАЙДАЛ

ГАЗАР ОЛГОЛТЫН ТУХАЙ

ГАЗАР АШИГЛАХ ЭРХИЙГ 2 ХЭЛБЭРЭЭР ЯВУУЛНА:

- Төсөл сонгон шалгаруулах
- Дуудлага худалдаа.

ХУГАЦАА

- 15 жил +
- Сунгалт хийж болно

№	Чөлөөт бүсийн нэр	1 га газрын суурь үнэлгээ (газар ашиглах зориулалтаар)	
		Худалдаа, бүх төрлийн үйлчилгээний	Үйлдвэрлэлийн
1	Алтанбулаг	120,000,000	80,000,000

№	Чөлөөт бүсийн нэр	Үйлдвэрлэлийн зориулалтаар			
		Суурь үнэлгээ (м ²)	Засварлах итгэлцүүр	Газрын хэмжээ (м ²)	800м ² газрын жилийн төлбөр
1	Алтанбулаг	8,000	0,08	800	512,000


№	Чөлөөт бүсийн нэр	Үйлдвэрлэлийн зориулалтаар			
		Суурь үнэлгээ (м ²)	Засварлах итгэлцүүр	Газрын хэмжээ (м ²)	800м ² газрын жилийн төлбөр
1	Алтанбулаг	12,0000	0,2	800	1,920,000

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ


ЭРЧИМ ХҮЧ, ДУЛААНЫ ЭХ ҮҮСВЭР, ШУГАМ СҮЛЖЭЭ, ЦЭВЭР УСАН ХАНГАМЖ, АРИУТГАХ, ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ, АВТО ЗАМ, ТӨМӨР ЗАМ, НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮНДСЭН СҮЛЖЭЭ ЗЭРЭГ ДЭД БҮТЭЦ БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛД: ЭХНИЙ 10 ЖИЛД 100 ХУВИАР ЧӨЛӨӨЛНӨ.

ХУДАЛДАА, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД: ЭХНИЙ ТАВАН ЖИЛД 100 ХУВЬ, ДАРААГИЙН ГУРВАН ЖИЛД 50 ХУВИАР ХӨНГӨЛНӨ;

НИЙТИЙН ЗОРИУЛАЛТАЙ АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ



АЛТАНБУЛАГ ЧӨЛӨӨТ БҮСИЙН ДЭД БҮТЦИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТРАСС







Монголчууд алс хол аян жин тээхдээ чимээ өгөх зорилгоор сүүлийн тэмээний хүзүүнд иймэрхүү хонх зүүдэг байжээ.

Жингийн хонх нэгэн хэмээр дуугарах тэр дууг "дууних" хэмээн нэрлэдэг байна.

Монгол Улс, Улаанбаатар дахь Төв оффис-15141
Чингэлтэй дүүрэг, Ж. Самбуу гудамж
Засгийн газрын 11-р байр
Утас: 976+51261430

Монгол Улс, Алтанбулаг чөлөөт бүс